“НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ” ХХК БОЛОН “ИНҮТ” ТӨХХК-ИЙН НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА ХООРОНДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

БАТАЛСАН	
Албан тушаал: “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Нэр: НОДА ТЭЦҮО Гарын үсэг: ..... Огноо: 2025.07.27	Албан тушаал: “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Нэр: Б.ОТГОНСҮХ Гарын үсэг: ..... Огноо: 2025.08.07
ХЯНАСАН	
Албан тушаал: “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал Нэр: Д.ЛХАГВАДОРЖ Гарын үсэг: ..... Огноо: 2025.07.22	Албан тушаал: “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Аюулгүй байдал, чанарын удирдлагын газрын дарга Нэр: П.ГАНТӨГС -г Гарын үсэг: ..... Огноо: 2025.08.05
БОЛОВСРУУЛСАН	
Албан тушаал: “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн Нисэх буудлын үйл ажиллагаа удирдлагын газрын дарга Нэр: А.АЗБИЛЭГ Гарын үсэг: ..... Огноо: 21/07/2025.	Албан тушаал: “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга Нэр: Д.БАЯРТОГТОХ Гарын үсэг: ..... Огноо: 2025.07.31.

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Өөрчлөлтийн дугаар	Хэвлэгдсэн огноо	Өөрчлөлтийн товч утга	Хамаарах хэсэг, хуудас
01	2024	Анхны хувилбар	Бүгд
02	2025	Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 193 дугаар тогтоолоор “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК байгуулагдаж, Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/290 дугаар тушаалын дагуу орсон зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт, шинэчлэн баталсан холбоотой өөрчлөлтүүдийг оруулсан. Товчилсон үгсийн тайлбар хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулсан.	Бүгд

АГУУЛГА

1. Ерөнхий зүйл

1.1. Үндсэн зорилго

1.2. Үндэслэл

1.3. Товчилсон үгийн тайлбар

1.4. Холбогдох байгууллагууд

2. Харилцан ажиллагаа

2.1. “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны хариуцах үйл ажиллагаа

2.2. “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн хариуцах үйл ажиллагаа

3. Бусад

3.1. Журмын үл нийцлийг илтгэх

3.2. Журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, дүгнэх

3.3. Журамд өөрчлөлт оруулах

3.4. Хариуцах ажилтнууд

3.5. Томилогдсон хариуцах ажилтнууд

Хавсралт 1. Мэдээлэл дамжуулах ерөнхий схем

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Үндсэн зорилго

1.1.1. Энэхүү журмын зорилго нь “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба (цаашид НУТА гэх) болон “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК (цаашид НУБИЭ ХХК гэх) хоорондын харилцан ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Үндэслэл

1.2.1. Энэхүү журам нь “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам”, НУТА-ны “Үйл ажиллагааны заавар”, ИНЕГ-ын “Цагийн хуваарийн зөвлөлийн ажиллах журам” болон “Чингис хаан” ОУНБ-ын “Нисэх буудлын ерөнхий заавар”-ын шаардлагуудыг үндэслэн боловсруулагдсан болно.

1.3. Товчилсон үгийн тайлбар

1.3.1. Энэхүү журамд дараах товчилсон үгсийг ашиглана. Үүнд:

• AFS	Нисэхийн суурин үйлчилгээ
• AODB	Нисэх буудлын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны мэдээллийн сан
• ИНҮТ ТӨХХК	“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК
• НБЭМ	Нисэх буудлын ээлжийн менежер
• НТБГ	Нислэгийн төлөвлөлт, бүртгэл, гүйцэтгэл
• НЦХЗХ	Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсэг
• НУБИЭ ХХК	Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК
• НУТА	Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба
• НУТБСБ	Нислэгийн урсгал төлөвлөлт, бүртгэл, санхүүгийн биллинг
• ОУНБ	Олон улсын нисэх буудал
• НБҮАУГ	Нисэх буудлын үйл ажиллагаа удирдлагын газар
• ШУХТ	Шуурхай удирдлага, хяналтын төв
• ҮАТХ	Үйл ажиллагааны төлөвлөлтийн хэлтэс
• ШТХ	Шуурхай төлөвлөлтийн хэсэг
• CDM	Хамтын шийдвэр гаргалт

1.4. Холбогдох байгууллагууд

1.4.1. “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба

Нислэгийн хөдөлгөөний урсгал, төлөвлөлтийн ойрын болон хэтийн чиг хандлагыг тодорхойлох, холбогдох баримт бичгийг боловсруулах, хууль

тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нислэгийн төлөвлөлт, урсгал зохицуулалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийгдэх олон улсын нислэгийн өнгөрөлт, олон улсын хөөрөлт, буулт болон орон нутгийн нислэгүүдэд зөвшөөрөл олгох, шуурхай төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах, агаарын тээвэрлэгчдээс ирүүлсэн нислэгийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлд судалгаа хийж, нислэгийн зөвшөөрөл олгох, нислэгийн хөдөлгөөний төлөвлөлтийн баримт бичгийн шинэчлэлт, боловсруулалт, баталгаажуулалтын ажлыг хариуцан хэрэгжүүлэх нэгж.

1.4.2. **“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК**

Иргэний нисэхийн дүрэм 139-ийн дагуу Аэродромын гэрчилгээ эзэмшиж, “Чингис хаан” ОУНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж.

2. ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

2.1. “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны хариуцах үйл ажиллагаа

2.1.1. НУТА нь нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, CDM-ыг хэрэгжүүлэхэд “НУБИЭ” ХХК-тай хамтран ажиллана.

2.1.2. Хуваарьт бус олон улсын нислэгийг “Чингис хаан” ОУНБ-ын хүчин чадалд нийцүүлэн “НУБИЭ” ХХК-ийн НБҮАУГ-ын ШУХТ-тэй airportops@nubia-llc.mn, dulguun.e@nubia-llc.mn цахим шуудан болон 71-287456 утсаар холбогдож хамтарч ажиллана.

2.1.3. Улаанбаатар – Ханбумбат чиглэлийн болон бусад 4C ангиллын агаарын хөлгөөр үйлдэх захиалгат орон нутгийн нислэгийг нисэх буудлын хүчин чадлыг харгалзан тухайн нислэгийг хүлээн авах боломжтой эсэх талаар “НУБИЭ” ХХК-ийн НБҮАУГ-ын ШУХТ-тэй airportops@nubia-llc.mn, dulguun.e@nubia-llc.mn цахим шуудан болон 71-287456 утсаар урьдчилан холбогдож, хамтран ажиллана.

2.1.4. ШТХ нь урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд орох өөрчлөлтийг тухай бүрд airportops@nubia-llc.mn цахим шуудангаар хүргүүлж хамтарч ажиллана.

2.1.5. НЦХЗХ нь хуваарьт нислэгийн нэмэгдэл болон өөрчлөлттэй холбоотой мэдээллийг НБҮАУГ-ын УАТХ-ийн javkhlan.n@nubia-llc.mn, subeedei.b@nubia-llc.mn болон airportops@nubia-llc.mn цахим шууданд хүргүүлж, Нисэх буудлын хүчин чадал болон зогсоолын хүрэлцээтэй эсэх талаар мэдээлэл солилцоно.

2.1.6. “Чингис хаан” ОУНБ-ын урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээг өмнөх өдрийн 18:00 цагт багтаан ШУХТ-ийн /airportops@nubia-llc.mn/ цахим шуудангаар хүргүүлнэ.

2.1.7. Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ нь дараах мэдээллүүдийг агуулсан байна. Үүнд:

- Аяллын дугаар
- Нисэн гарах нисэх буудал, цаг
- Нисэн очих нисэх буудал, цаг
- Агаарын хөлгийн маяг, дугаар
- Тайлбар

2.1.8. Шуурхай төлөвлөлтөөр нэмэгдэж байгаа хуваарьт бус нислэг болон нислэгийн өөрчлөлтийн мэдээллийг AFS сүлжээгээр үнэн зөв дамжуулна.

2.1.9. Гадаадын агаарын тээвэрлэгчийн "Чингис хаан" ОУНБ-д үйлдэгдэх хуваарьт бус нислэгийн хүсэлтийг (зөвшөөрөл олгосон тохиолдолд) тухай бүрд "НУБИЭ" ХХК-ийн Нисэх буудлын маркетингийн хэлтэст marketing@nubia-llc.mn цахим шуудангаар хүргүүлнэ.

2.1.10. "Чингис хаан" ОУНБ-д үйлдэгдсэн нислэгийн гүйцэтгэлийн 7 хоногийн мэдээ, тайланг "НУБИЭ" ХХК -ийн Нисэх буудлын маркетингийн хэлтсийн marketing@nubia-llc.mn цахим шуудан болон Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн finance@nubia-llc.mn цахим шуудангаар хүргүүлнэ.

2.1.11. Цаг агаар болон бусад шалтгааны улмаас төлөвлөгдсөн нислэгүүд олон цагаар саатаж, нисэх буудалд ачаалал үүссэн талаар "НУБИЭ" ХХК-ийн НБҮАУГ-ын ШУХТ-өөс мэдэгдсэн тохиолдолд ачааллыг зохицуулах зорилгоор нислэгүүдийг дахин төлөвлөхдөө "НУБИЭ" ХХК болон агаарын тээвэрлэгчидтэй хамтран CDM-ыг хэрэгжүүлэх ажлыг хариуцан ажиллана.

2.1.12. Нисэх буудал нь нэгэн зэрэг таван 4E болон түүнээс дээш ангиллын зорчигч тээврийн агаарын хөлгийг хүлээн авах боломжгүй тул 4E болон түүнээс дээш ангиллын зорчигч тээврийн агаарын хөлгөөр нислэг үйлддэг агаарын тээвэрлэгчдийн нислэгийн цагийг зөрүүлэх зохицуулалтыг хийнэ.

2.1.13. Нислэгийн оргил ачаалалтай цагуудад 4C болон түүнээс дээш ангиллын ачаа тээврийн зориулалттай агаарын хөлгүүд (Ил-76, C130, C17 болон Ан-124 гэх мэт) өөрийн чирэгч хатуу холбоостой бол нислэг үйлдэх зөвшөөрөл олгох, хэрэв чирэгч хатуу холбоос байхгүй бол тухайн цагуудад зөвшөөрөл олгохгүй байх арга хэмжээг авна.

2.1.14. "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-д өөрчлөлт орсон тохиолдолд "НУБИЭ" ХХК-ийн удирдлага, холбогдох нэгжид цаг тухайд нь албан тоотоор хүргүүлнэ.

2.1.15. НУТА нь урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ болон нислэгийн төлөвлөлтөд орсон өөрчлөлтийн мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

2.1.16. Онцгой нөхцөл байдлын үеийн аливаа мэдээллийг "НУБИЭ" ХХК-ийн ШУХТ-д /71-287320 утсанд/ шуурхай дамжуулна.

2.2. "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн хариуцах үйл ажиллагаа

2.2.1. “НУБИЭ” ХХК нь Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент, CDM-ыг хэрэгжүүлэхэд НУТА-тай хамтран ажиллана.

2.2.2. Цаг агаар болон бусад шалтгааны улмаас төлөвлөгдсөн нислэгүүд олон цагаар саатаж, нисэх буудалд ачаалал үүссэн тохиолдолд ШУХТ-өөс НУТА-ны ШТХ-т /71-281602 утсаар/ ачааллын талаар мэдэгдэнэ. (Нислэгийн саатлаас шалтгаалан үүссэн зорчигч урсгалын бөөгнөрөл, агаарын хөлгийн зогсоолын хэрэгцээ, хөдөлгөөний эрчимжилт хэтэрсэн, нислэг үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг ачаалал хэтэрсэн үе гэж ойлгоно.)

2.2.3. НУТА-наас ирүүлсэн нислэгийн төлөвлөлтийн нислэгийн мэдээнд орсон өөрчлөлтүүд болон шуурхайгаар нэмэгдэж байгаа хуваарьт бус нислэгийн мэдээллийг ШУХТ нь AODB-д оруулна.

2.2.4. НУТА-наас ирүүлсэн урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ, мэдээлэл болон нислэгийн төлөвлөлтөд орсон өөрчлөлтүүд (хойшилсон, цуцалсан, өөрчлөгдсөн, нэмэгдсэн)-ийн мэдээ, мэдээллээр ШУХТ нь нисэх буудлын холбогдох нэгжүүдийг хангаж ажиллана.

2.2.5. “НУБИЭ” ХХК-ийн “Нисэх буудлын ерөнхий заавар” болон энэхүү журамтай холбоотой бусад баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийн талаар НУТА-нд цаг тухайд нь албан тоотоор хүргүүлнэ.

2.2.6. НУТА-наас гаргасан урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд үндэслэн, “НУБИЭ” ХХК нь зорчигч, үйлчлүүлэгчдэд нислэгийн мэдээллийг хүргэнэ.

2.2.7. Онцгой нөхцөл байдлын үеийн аливаа мэдээллийг НУТА-ны Нислэгийн төлөвлөлтийн ээлжийн мэргэжилтэнд /71-281602 утсанд/ шуурхай дамжуулна.

2.2.8. НБЭМ нь ШТХ-ээс tpu@mcaa.gov.mn цахим шуудангаар ирүүлсэн нислэгийн өөрчлөлтөд нисэх буудлын хүчин чадалтай уялдуулан боломжит хариуг тухай бүрд шуурхай хүргүүлнэ.

2.2.9. ШУХТ-ийн хэлтсийн дарга нь НЦХЗХ-ээс fpd@mcaa.gov.mn цахим шуудангаар ирүүлсэн захиалгат, онцгой, тусгай үүргийн,нислэгийн мэдээллүүдэд нисэх буудлын хүчин чадалтай уялдуулан боломжит хариуг тухай бүрд шуурхай хүргүүлнэ.

2.2.10. ШУХТ-ийн хэлтсийн дарга нь НЦХЗХ-ээс fpd@mcaa.gov.mn цахим шуудангаар ирүүлсэн Улаанбаатар – Ханбумбат чиглэлийн болон бусад 4С ангиллын агаарын хөлгөөр үйлдэх захиалгат орон нутгийн нислэгийн мэдээллийг нисэх буудлын хүчин чадалтай уялдуулан үнэлж, боломжит хариуг тухай бүрд шуурхай хүргүүлнэ.

2.2.11. ҮАТХ нь НЦХЗХ-ээс fpd@mcaa.gov.mn цахим шуудангаас ирүүлсэн хуваарьт нислэгийн өөрчлөлт, нэмэгдэлд нисэх буудлын хүчин чадалтай уялдуулан боломжит хариуг тухай бүрд шуурхай хүргүүлнэ.

3. БУСАД

3.1. Журмын үл нийцлийг илтгэх

3.1.1. НУТА нь энэхүү журмын заалтуудыг зөрчсөн тохиолдолд НУТА-нд албан тоотоор мэдэгдэнэ.

3.1.2. "НУБИЭ" ХХК нь энэхүү журмын заалтуудыг зөрчсөн тохиолдолд "НУБИЭ" ХХК –д албан тоотоор мэдэгдэнэ.

3.1.3. Үл нийцэл илэрсэн тохиолдолд залруулах, дахин давтагдахаас сэргийлэх зорилгоор тохирох арга хэмжээг талууд хамтран төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.2. Журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, дүгнэх

3.2.1. Энэхүү журмын хэрэгжилтэд хоёр тал жил тутам дүн шинжилгээ хийнэ.
3.2.2. Нэгжийн удирдлагууд улирал бүрийн сүүлийн долоо хоногийн даваа гарагт журмын хэрэгжилт, нислэг төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар хэлэлцэж, санал солилцоно.

3.3. Журамд өөрчлөлт оруулах

3.3.1. Энэхүү харилцан ажиллагааны зохицуулалтын журамд өөрчлөлт, нэмэлт оруулах саналыг хоёр тал албан тоотоор гаргана.

3.3.2. Журамд оруулах саналыг хоёр тал харилцан зөвшөөрсөн тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

3.3.3. Энэхүү журамд тусгагдсан утас болон факсын дугаар, цахим шууданд өөрчлөлт орсон тохиолдолд албан тоотоор мэдэгдэнэ.

3.4. Хариуцах ажилтнууд

ХҮСНЭГТ 1:

Байгууллага	**Үндсэн хариуцагч**	**Хоёрдогч хариуцагч**
1. Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба		
Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба	Г.Мөнгөлдэй НЦХЗХ-ийн дарга	Т.Батбаяр НУТА-ны дарга
	Утас: 71-283330 Ц/ш: munguldei@ncac.mn	Утас: 71-285086 Ц/ш: batbayar.t@ncacmn
2. "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК"		
"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК	Н.Жавхлан УАТХ-ийн дарга	А.Азбилэг НБҮАУГ-ын дарга
	Утас: 71-287390	Утас: 71-287307

	Ц/ш:javkhlan.n@nubia-llc.mn	Ц/ш: azbileg.a@nubia-llc.mn
	Э.Дөлгөөн ШУХТ-ийн хэлтсийн дарга	
	Утас: 71-287456 Ц/ш:dulguun.e@nubia-llc.mn	

3.5. Томилогдсон хариуцах ажилтнууд

ХҮСНЭГТ 2:

Мэдээлэл	**НУТА**	**“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК**
Мэдээлэл солилцох нэгж, ажлын байр	НЦХЗХ-ийн нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн	ШУХТ-ийн ээлжийн менежер
	Утас: 71-282029 Ц/ш: fpd@mcaa.gov.mn	Утас: 71-287300 Ц/ш: airportops@nubia-llc.mn
	ШТХ-ийн нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн	ШУХТ-ийн нислэг төлөвлөлт, нисэх буудлын мэдээллийн зохицуулагч
	Утас: 71-281602 Ц/ш: tpu@mcaa.gov.mn AFTN: ZMUBZGZX	Утас: 71-287320 Ц/ш: airportops@nubia-llc.mn AFTN: ZMCKYDYX

Хавсралт 1.

МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ЕРӨНХИЙ СХЕМ

